БАТЛАВ

ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.НАСАНЖАРГАЛ

БАТЛАВ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 03 сарын 25-ны өдөр 2025/04 Дугаар Зуунмод хот

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар, даалгавар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	Газрын тухай хуулийн 24 дэх зүйлийн 24.1-д заасан Газар зохион байгуулалтын цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан "Газар зохион байгуулалт хийх журам", ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн А/304 дүгээр тушаалаар батлагдсан "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө аргачлал"
2.	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Баянцагаан сумын байгалийн нөөц, нөхцөл, уур амьсгал, газар ашиглалтын онцлог, нийгэм, эдийн засаг, соёл, амьдралын уламжлалт хэв маяг, онцлогийг судлан тодорхойлж, газар ашиглалтын хэрэгцээт болон тохиромжтой байдлын үнэлгээнд үндэслэн иргэд, олон нийтийн жигд оролцоотойгоор нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, бусад бодлогын баримт бичигт тулгуурласан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад энэхүү аргазүйн зорилго оршино.
3.	Баримтлах зарчим	• Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэх; • Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах; • Иргэд, олон нийтийн оролцоог хангасан, хүний эрх, жендерийн тэгш байдлыг хангасан, ардчилсан, хэрэгжихүйц байх; • Байгаль орчинд ээлтэй байх; • Үр ашигтай байх; • Орон нутгийн өрсөлдөх чадварыг дэмжихийн зэрэгцээ өнөө ба ирээдүй хойч үеийн хэрэгцээг хангасан тогтвортой хөгжлийг баримталсан байх; • Ил тод нээлттэй байх; • Хяналт, үнэлгээ хийх боломжтой байх • Оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөсөн, улс, орон нутгийн хөгжлийн бодлого, хэтийн зорилт, хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, үр дүнг хангахад чиглэсэн байх;

		• Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний зураг төсөл түүнтэй холбоотой бусад суурь судалгааны мэдээллүүд нь геодезийн байрлал, өндрийн нэгдсэн тогтолцоонд зохиогдсон байх.
4.	Ажлын хамрах хүрээ	Төв аймгийн Баянцагаан сумын нийт нутаг дэвсгэр 647420 га талбай
5.	Ажил гүйцэтгэх хугацаа	Эхлэх хугацаа: 2025 оны.....сарын.....өдөр Дуусах хугацаа: 2025 оны.....сарын.....өдөр
6.	Гүйцэтгэх ажлын хэмжээ	Гүйцэтгэх ажлын хэмжээ нь ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн А/304 дугаар тушаалаар батлагдсан "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний аргачлал"-д заасан үе шат бүрээр тодорхойлогдох бөгөөд дараах үе шаттай байна. **1. БЭЛТГЭЛ ҮЕ ШАТ** **Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг судлах, уялдуулах** Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа улс, бүс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй нарийвчлан тодруулж түүнд нийцүүлэн, сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд шууд тусгаж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ. **Хөгжлийн бодлогын баримт бичиг, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны тайланг судлах, уялдуулах** Улс, бүс, аймаг, сумын чанартай бодлогын баримт бичгийг судлаж тухайн сумтай холбоотой бодлого, арга хэмжээ, үйл ажиллагааны жагсаалтыг гаргана. Ялангуяа тухайн суманд хэрэгжиж буй, зохих эрх бүхий этгээдээр албан ёсоор батлагдсан хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн баримт бичгийг сайтар судлаж тэдгээрийг хэрэгжүүлэх орон зайн болон газар, байгалийн нөөцийн чадавхийн боломжийг үнэлж дүгнэн, бодит шийдлийг тодорхойлж түүнтэй уялдуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах. Усны нөөцийн менежментийн нэгдсэн төлөвлөгөө, ойн менежмент, бэлчээрийн менежмент эсвэл тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, түүнчлэн холбоос нутаг, нүүдлийн зүйлийн талаар хийсэн судалгааны үр дүнд тогтоосон газар нутгууд гэх мэт тусгай салбарын менежментийн төлөвлөгөөг судалж төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх, уялдуулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлох. **Байгалийн нөөц, нөхцөл, төрх байдлыг судлах** Улс, аймаг, сумын нутаг дэвсгэр дээр хийгдэж байсан бүх төрлийн байгалийн нөөц, нөхцөл, төрх байдлын судалгааны ажлыг судалж, нэгтгэн газар зүйн мэдээллийн системийг ашиглаж, тоон хэлбэрт оруулж, сэдэвчилсэн зургийн эхний хувилбарыг бэлтгэнэ.

		Сэдэвчилсэн зураг хийхдээ "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-д заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу зураглана. **Нийгэм эдийн засгийн мэдээлэл бүрдүүлэх** Хээрийн судалгааны үе шатанд хийгдэх нийгэм, эдийн засгийн судалгаанд ашиглагдах мэдээг байрлалд суурилсан "Нийгэм, эдийн засгийн мэдээллийн сан" болон холбогдох байгууллагуудаас авч, цуглуулна. **Газрын нэгдмэл сан, түүний ашиглалтын суурь судалгаа** Сумын нутаг дэвсгэрт өмнө хийгдэж байсан газар ашиглалттай холбоотой судалгааны тайлан, газрын нэгдмэл сангийн тайлан, газрын кадастрын мэдээллийн сангийн бүртгэл, бусад мэдээллийг цуглуулж, хөдөө аж ахуй, тусгай хэрэгцээ, ой, усны сан бүхий газар, зам шугам сүлжээний газар ашиглалтыг зориулалт бүрээр 1:100000, 1:50000, 1:25000, 1:10000 масштаб, хот суурингийн газар, аялал жуулчлалын газар, уул уурхайн газар, хөдөө аж ахуйн суурин газарт 1:10000, 1:5000, 1:1000 масштаб зэрэг харгалзах хамгийн том масштабтайгаар сэдэвчилсэн зургийн эхний хувилбарыг бэлтгэнэ. **Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх** Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргазүй"-н дагуу тухайн сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу том масштабын шаардлагад нийцсэн мэдээллийн нарийвчлалыг хангаж ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг дээрх арга зүйн дагуу хийнэ. Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг дээр дурдсан аргачлалын дагуу газар ашиглалтын дараах төрлүүдээр хийнэ. Үүнд: • Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ; • Бэлчээр ашиглалтын газрын тохиромжтой байдлын үнэлгээ; • Хадлангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ • Газар тариалангийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ; • Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ; • Эрчимжсэн фермерийн аж ахуй хөгжүүлэх газрын тохиромжтой байдлын үнэлгээ; • Жимс, жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ; • Шинээр байгуулах, өргөтгөх, нөөц газар сонгох зорилготой хот, тосгон, бусад суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ; • Аялал жуулчлалын бүс, замналын тохиромжтой байдлын үнэлгээ; • Хөв цөөрөм байгуулахад тохиромжтой байдлын үнэлгээ; • Ойжуулахад тохиромжтой байдлын газрын үнэлгээ;

		• Тусгай хамгаалалтад авах зориулалттай газрын тохиромжтой газрын үнэлгээ; • Инженерийн шугаман байгууламжийн зориулалттай газрын тохиромжтой байдлын үнэлгээ; • Төлөвлөгөөнд шаардлагатай бусад газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ. **Хэрэгцээт байдлын үнэлгээ хийх** Нийгэм, эдийн засгийн газрын хэрэгцээт байдлыг дараах чиглэлүүдээр тодорхойлно. Үүнд: Нийгмийн дэд бүтцийн газрын хэрэгцээ /сургууль цэцэрлэг, эмнэлэг, соёл, урлаг гэх мэт төрийн байгууллага, ногоон байгууламж, эмийн сан гэх мэт/ • Инженерийн дэд бүтцийн газрын хэрэгцээ /цахилгаан дамжуулах шугам, зам, халуун, хүйтэн усны шугам гэх мэт/ • Шинээр эзэмшүүлэх, өмчлүүлэх газрын хэрэгцээ • Хүн амын ундны усны хэрэгцээ • Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, тариалангийн газрын хэрэгцээ • Малын тэжээлийн хэрэгцээ, хадлангийн газрын хэрэгцээ • Худаг, усан сангийн хэрэгцээ • Бусад шаардлагатай хэрэгцээт байдлын үнэлгээ **Бэлтгэл ажлын тайлан хүргүүлэх** • Мэргэжлийн байгууллага бэлтгэл ажлын тайланг боловсруулж аймгийн газрын алба, сумын газрын даамалд хүргүүлж, дүгнэлт, зөвлөмж гаргуулна. • Аймгийн газрын алба, сумын газрын даамал бэлтгэл ажлын тайланд захиалагчийн хяналтыг хийж, ажлын хэсгээр хэлэлцүүлэн дүгнэлт, зөвлөмжийг мэргэжлийн байгууллага болон ГЗБГЗЗЕГ-т хүргүүлнэ. **1. ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮЕ ШАТ** Хээрийн судалгааны үе шатанд гүйцэтгэсэн ажлын тайланг орон нутгийн удирдлагууд болон ажлын хэсэгт танилцуулна. **Газар ашиглалтын одоогийн байдлыг тодруулах** "Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"- д заасны дагуу газар дээр нь очиж ажиллах, хэмжилт, зураглал, тодруулалт хийх чиглэлүүд, баг бүрэлдэхүүнийг тогтооно. Хээрийн хэмжилт, тодруулалтын ажилд сумын удирдлага, газрын даамал, багийн Засаг дарга нарыг оролцуулах ба шаардлагатай бусад мэргэжилтнүүдийг тэд нартай тохиролцсоны үндсэн дээр оролцуулж, газрын нэгдмэл сангийн ангиллын дагуу байршил, заагийг нарийвчлан зураглана.

		Хил зааг тогтоож зураглалыг хийх MNS 6317: 2012, MNS 6316:2012 стандартыг ашиглана. Хэмжилт судалгаа зураглал нь сумын нийт нутаг дэвсгэрийг хамарсан газар ашиглалтын төрлүүд түүний хил зааг, байршил тогтоож хэмжилт зураглал хийнэ. Зүй ёсны эрхийн зориулалтын төрлүүд болон газар, байгалийн нөөцийн тархац, хэмжээг төрөл бүрээр нь газар дээр нь иргэдтэй хамтран тогтоож зураглах. Ялангуяа бэлчээрийн улирлын хуваарь, нийтээр болон гэрээгээр ашиглуулах бэлчээр, малчдын өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, худаг уст цэг болон бэлчээр ашиглалтын бусад төрлийг хэмжиж зураглан, тэдгээрт байрших малын тоог тухайн оны Мал тооллогын А дансны мэдээллээс авч хүснэгтийн атрибут мэдээлэлтэй холбож Shp файл үүсгэнэ. **Статистик мэдээ цуглуулах** Бэлтгэл ажлын хүрээнд бэлтгэсэн хүснэгтэн мэдээний загвараар сумын статистикийн мэдээллээс нийгэм эдийн засгийн холбоотой шаардагдах тоон мэдээллийг авна. **Иргэд, олон нийтээс санал авах оролцоог хангах** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал болон Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан "Газар зохион байгуулалт хийх журам"-ын 3.17.1, 3.17.3-т заасны дагуу иргэд олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, төрийн болон төрийн бус байгууллага, сумдын Засаг дарга нар, олон нийтээс саналыг авна. **Тохиромжтой байдлын үнэлгээг газар дээр тулгах** Бэлтгэл ажлын хүрээнд бэлтгэсэн тохиромжтой байдлын үнэлгээний таарцыг газар дээр тулгаж үзнэ. **Газрын доройтлын зэргийг үнэлэх, зураглах** - ХАА-н газрын доройтол /хөрсний элэгдэл, ялзмаг болон шим тэжээлийн алдагдал/, бэлчээрийн даац хэтрэлт, уул уурхайн сөрөг нөлөөллийн тооцоо судалгаа, газрын байршил талбайн хэмжээг тодорхойлох. - Тариалангийн талбайн салхи, усны элэгдэл, үржил шимийн алдагдал тодорхойлох - Бэлчээрийн газрын өөрчлөлтийг үнэлэх фото мониторингийн судалгааны мэдээлэлд үндэслэн бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх. - "Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал өөрчлөлтийн загвар"-ыг ашиглан бэлчээрийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох. - Зам шугам сүлжээний газрын зэрлэг амьтны байршил, шилжилт хөдөлгөөнд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, малчдын нүүдэлд учруулж буй бэрхшээлийн судалгаа, зураг. - Газар ашиглалтаас усны нөөцийн хомсдол, бохирдолд үзүүлж буй сөрөг нөлөөллийн судалгаа зураг

2. ЭХНИЙ ТӨСӨЛЖҮҮЛЭЛТ

Сумын хөгжлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх:
Сумын нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтэц, газрын харилцааны чиглэлүүдээр СВОТ(SWOT) шинжилгээ буюу гадаад, дотоод орчны судалгаа болон ПЭСТЭЛ (PESTEL) болон асуудлын шинжилгээний аргуудыг хослуулан хэрэглэж одоогийн байдал, тулгамдаж буй бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх нөөц чадавх боломжуудыг тодорхойлно.

Тохиромжтой байдлын үнэлгээ, хэлэлцүүлэг саналд үндэслэн газар ашиглалтын төлөвлөлтийн бүсчлэлийг тогтоох

Хөдөө аж ахуйн газрын төлөвлөлт

Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн бүс
- Улирлын хуваарийн /өвөл-хавар, зун-намар/ сэлгээ тогтоосон бэлчээр
- Сүргийн эргэлт бүтцийн төлөвлөгөө
- Газар сайжруулалтын арга хэмжээ тусгайлан заасан бэлчээр
- Усжуулах шаардлагатай бэлчээр
- Отрын бэлчээр ашиглалтын бүс
- Сэргэх чадавхад суурилсан бэлчээрийн газрын менежментийн арга хэмжээ тусгасан нутаг
- Отрын мал тууврын зам
- Зэрлэг амьтдын дамжин өнгөрөх коридор
- Бэлчээрийн төлөв байдал, төрх байдлыг тодорхойлох
- Бэлчээрийн даац багтаамжыг тооцох /төлөвлөлтийн хугацааны малын тоонд уялдуулах/
- Бусад

Тусгай горимын зохицуулалттай бэлчээр ашиглалтын бүс
- Тусгай горимын зохицуулалттай бэлчээр ашиглалтын бүс /тусгай хамгаалалттай газар нутаг/
- Хорио цээрийн дэглэм тогтоосон бүс
- Отрын бүс нутаг
- Бусад

Эрчимжсэн мал аж ахуйн газрын бүс
- Эрчимжсэн мал аж ахуйн бүс
- **Хагас эрчимжсэн мал ахуйн бүс**

Хадлангийн газрын менежмент

Байгалийн хадлангийн талбай
- Аймаг дундын хадлангийн талбай
- /тусгай хэрэгцээ/
- Сум дундын хадлангийн талбай
- Сумын хадлангийн талбай
- Хөцөөлсөн хадлангийн талбай
- Бусад

Таримал хадлангийн талбай
- Таримал хадлангийн талбай

Сайжруулах хадлангийн талбай

		- Нөөшлөх хадлангийн талбай - Төрх байдлыг сайжруулах талбай - Өнгөц тордон сайжруулалт хийх талбай - Үндсэн сайжруулалт хийх талбай - Хадах хугацаа, сэлгээ хийх талбай - Бусад **Тариалангийн газрын төлөвлөлт** **Атар зэмших талбай, Дахин эргэлтэнд оруулах атаршсан талбай** - Үр тариа - Төмс, хүнсний ногоо - Тэжээлийн ургамал - Тосны ургамал - Техникийн ургамал - Эмийн, гоёл чимэглэлийн ургамал - Бусад **Эргэлтэнд оруулахгүй атаршсан талбай** - Хадгалах талбай - Түр өөр зориулалтаар ашиглах талбай - Бусад ангилал руу шилжүүлэх талбай **Тариалангийн талбайн хамгаалалтын зурвас** - Эргэлт-ашиглалтын зурвас /100 м/ - Хамгаалалтын зурвас /500 м/ **Тариалангийн талбайг хамгаалах, арчилж тордох, сайжруулах бүс** - Төрх байдлыг сайжруулах шаардлагатай талбай - Тордон сайжруулалт хийх шаардлагатай талбай - Бэлчээр, хадлангийн зориулалтаар нөхөн сэргээлт хийх талбай - Хамгаалалтын ойн зурвас - Усалгаатай газар тариаланд шилжих талбай - Тариалангаас бусад ангилал руу шилжүүлэх талбай - Бусад **ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газрын төлөвлөлт** **Худаг уст цэгийн барилга, байгууламж бүхий бэлчээр** - Уст цэгийн хайгуул хийх нутаг - Засварлах шаардлагатай худаг уст цэг **Хөв цөөрмийн барилга, байгууламж төлөвлөх бэлчээр** - Бэлчээрийн зориулалтаар шинээр байгуулах хөв цөөрмийн газар - Бэлчээрийн зориулалттай сэргээн засварлах шаардлагатай хөв цөөрмийн газар **Газар тариалангийн барилга, байгууламжийн дэвсгэр газар /Бүсийн шалгуур хангасан тохиолдолд төлөвлөнө/** - Шинээр услалтын систем байгуулах газар - Сэргээн засварлах шаардлагатай услалтын системтэй талбай - ХАА-н бүтээгдэхүүний логистик төв - Хөдөө аж ахуйн цогцолбор бүс

		- Газар тариалангийн зориулалтаар шинээр байгуулах хөв цөөрмийн газар - Газар тариалангийн зориулалттай сэргээн засварлах шаардлагатай хөв цөөрмийн газар - Бусад **Хадгалан хамгаалах газрын төлөвлөлт** Газар нөөшлөх бүс - Зөгийний аж ахуйн бэлчээр - Ан амьтны үржүүлгийн нутаг - Ашиглахгүй нөөшлөх нутаг - Бусад **Чөлөөт ашиглалтын бэлчээрийн бүс** - Чөлөөт ашиглалтын бэлчээр /1.1-ээс 1.5 хүртэлх бүсчлэлд төлөвлөгдөөгүй бусад газар/ **Хот тосгон бусад суурины газар төлөвлөлт** - Хот тосгон, бусад суурины газрын газар ашиглалтын байдлыг үнэлж, одоо байгаа хот тосгон, бусад суурины эдэлбэр газрыг тэлэх, өөрчлөх байршил, хэмжээг төлөвлөлтийн хугацааны хүн амын өсөлт, хэрэгцээт байдлын үнэлгээ болон орон нутгийн саналд үндэслэн төлөвлөх; - Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг үнэлэх, шаардлага хангахгүй, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжиж дуусан эсвэл зохиогдоогүй нөхцөлд хот суурины функциональ бүсчлэлийг Хот байгуулалтын тухай хууль, "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30.01.04 дагуу орон нутгийн онцлогт нийцүүлэн тогтоож, төлөвлөх /төлөвлөх эсэхийг захиалагчтай зөвшилцөх/ **Суурьшлын бүс** - Хуваарьт эдлэн газартай хувийн сууцны бүс - Нам давхрын орон сууцны бүс - Дунд давхрын орон сууцны бүс - Өндөр давхрын орон сууцны бүс - Гэр хорооллын бүс - Бусад **Олон нийт, ажил хэргийн бүс** - Олон нийт, ажил хэргийн бүс - Худалдаа, ажил хэргийн бүс - Үйлчилгээний төрөлжсөн бүс - Тээвэр, бөөний худалдаа, агуулахын бүс - Бусад **Хот тэлэх нөөц бүс** **Ногоон байгууламжийн бүс** - Ногоон байгууламж задгай талбай - Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн бүс - Тусгай зориулалтын ойн зурвас, талбай - Бусад **Холимог ашиглалтын бүс** - Үйлдвэр, сууцны холимог бүс - Худалдаа, үйлдвэр, сууцны холимог бүс - Үйлдвэр, худалдааны холимог бүс - Бусад

		Инженерийн шугам сүлжээ, зам тээврийн бүс - Инженерийн шугам сүлжээний бүс - Инженерийн барилга байгууламжийн бүс - Гудамж, зам, болон шугаман дэд бүтцийн хамгаалалтын бүс - Бусад **Тусгай зориулалтын бүс** - Тусгай зориулалтын бүс - МАА эрхлэхийг хориглох бүс **Хот орчмын ногоон бүс** - Зуслангийн бүс - Рекреацийн бүс /Амралт зугаалгын бүс/ - Экологийн хязгаарлалттай бүс - Бусад **Хот орчмын хөдөө аж ахуйн бүс** - Эрчимжсэн мал аж ахуйн бүс - Хагас эрчимжсэн мал ахуйн бүс - Хучлагат хөрсний ногооны аж ахуйн бүс - Бусад **Уламжлалт ёс заншлын бүс** - Уламжлалт ёс заншлын болон наадмын талбай - Уламжлалт ёс заншлын талбайн хамгаалалтын бүс - Уламжлалт баяр, наадмын морин уралдааны зам - Бусад **Үйлдвэрийн бүс** - Хөнгөн үйлдвэр - Хүнд үйлдвэр - Бусад **Тусгай зориулалттай бүс нутгийн төлөвлөлт** **Хог хаягдлын газрын менежментийн бүс** - Төлөвлөж буй хог хаягдлын бүс - Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж буй хог хаягдлын бүс - Төлөвлөж буй хог хаягдал боловсруулах үйлдвэрийнн талбай - Хог хаягдлын талбайн хамгаалалтын бүс Оршуулгын газрын менежментийн бүс - Төлөвлөж буй энгийн уламжлалт оршуулгын газар - Төлөвлөж буй тохижилттой уламжлалт оршуулгын газар - Төлөвлөж буй чандарлах үйлчилгээтэй оршуулгын газар - Тохижуулалт хийхээр төлөвлөж оршуулгын газар - Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж буй оршуулгын газар - Бусад **Тусгай зориулалттай бүс** - Батлан хамгаалах аюулгүй байдлыг хангах зориулалттай газар - Тэсэрч, дэлбэрэх бодисын агуулахын бүс - Төлөвлөж буй аюултай хог хаягдлын бүс - Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар

		- Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай - Түүх соёлын дурсгалыг хадгалан хамгаалах бүс - Бусад **Уул уурхайн газрын төлөвлөлт** **Уул уурхайн газар /холбогдох хууль, журмын дагуу/** - Ашиглалтын тусгай зөвшөөрөл лиценз бүхий талбай - Хайгуулын тусгай зөвшөөрөл лиценз бүхий талбай - Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж буй эвдэрсэн газар - Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ авах нутаг - Бусад **Түгээмэл тархацтай ашигт малтмалын уурхайн газар /Холбогдох хууль, журмын дагуу/** - Ашиглахаар төлөвлөж буй түгээмэл тархацтай ашигт малтмалын уурхай - Хайгуул болон нөөц тогтоолгохоор төлөвлөж түгээмэл тархацтай ашигт малтмалын уурхай - Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж эвдэрсэн газар - Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ авах нутаг - Бусад **Усны сан бүхий газрын төлөвлөлт** **Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс** - Онцгой хамгаалалтын бүс - Энгийн хамгаалалтын бүс **Ундны усан хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс** - Эрүүл ахуйн хориглолтын бүс - Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс - Гадаад тэжээгдэх муж - Дотоод тэжээгдэх муж - Бусад **Усны эх газрыг хамгаалах бүс** - Гол, горхины эх газрын хамгаалалтын бүс - Булаг шандын тархи эх газрын хамгаалалтын бүс - Усархаг чийглэг газар - Усны эх газрын хамгаалах тусгай зориулалтын ойн зурвас - Бусад **Ой сан бүхий газрын төлөвлөлт** **Онцгой бүсийн ой** **Хамгаалалтын бүсийн ой** **Ашиглалтын бүсийн ой** - Ойн нөөцийг ашиглах бүс - Ойн орчин ашиглах бүс - Ойн дагалт баялгийг ашиглах бүс - Ойн газрыг ашиглах бүс - Бусад **Агро-ойжуулалт хийх менежментийн бүс** - Шинээр ойжуулах бүс - Мод үржүүлэг, тарьц суулгац бэлдэх талбай

		- Агро-ойжуулалт хийх талбай - Жимс, жимсгэнэ мод, бут тариалах бүс - Бусад **Ойн нөөцийг хамгаалах, тордох, нөхөн сэргээх менежментийн бүс** - Ойн нөөцийг хамгаалах бүс - Гал түймрээс хамгаалах зурвас - Ойг хөнөөлт шавж, ургамлын өвчнөөс хамгаалах ой - Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж буй ой - Байгалийн сэргэн ургалтыг дэмжих ой - Бусад **Аялал жуулчлалын бүсийн төлөвлөлт** **Байгалийн нөөц, соёлын өвд тулгуурласан аялал жуулчлалын бүс** - Байгалийн үзэсгэлэн өвд тулгуурласан аялал жуулчлалын бүс - Соёлын өв нөөцөд тулгуурласан аяллын бүс - Байгалийн танин мэдэхүйн аялал жуулчлалын бүс - Бусад **Хил орчмын аялал жуулчлалын бүс** **Түүх соёлын ул мөртэй танилцах аялал жуулчлал** - Байгаль түүхийн ул мөртэй танилцах аяллын маршрут - Газар хөдлөлтийн ул мөртэй танилцах аяллын маршрут - Түүх соёлын ул мөртэй танилцах аяллын маршрут - Хүн үүслийн ул мөртэй танилцах аяллын маршрут - Бусад **Экстрим аялал жуулчлал хөгжүүлэх бүс** - Газрын экстрим аялалын газар - Агаарын экстрим аялалын газар - Усны экстрим аялалын газар - Бусад **Тусгай сонирхлын аялал жуулчлалын бүс** - Ан агнуурын аялал жуулчлалын бүс - Шувуу ажиглах аялал жуулчлалын бүс, маршрут - Зэрлэг амьтан ажиглах аялал жуулчлалын бүс - Эмийн ургамлын аялал жуулчлалын бүс - Галт уул сонирхогчдын аялал жуулчлалын бүс - Шашны аялал жуулчлалын бүс - Бусад **Амралт, эрүүл мэндийн аялал жуулчлалын бүс** - Амралт сувиллын бүс - Рашаан сувиллын бүс - Бусад **Зохион байгуулалттай спорт амралтын бүс** - Тэмээн поло аялал жуулчлалын газар - Гольф тоглох аялал жуулчлалын газар - Уулын спортын аялал жуулчлалын газар

		- Нохой чарганы зохион байгуулалттай аялал жуулчлалын газар - Орон нутгийн эвент арга хэмжээний аялалын газар - Бусад **Зам шугам сүлжээний газрын төлөвлөлт** **Төмөр замын зурвас газар** **Авто замын зурвас газар** **Шугам сүлжээний хамгаалалтын бүс** **Агаарын тээврийн газар** - Байнгын ажиллагаатай нисэх буудал - Байнгын бус, нөөц, түр нисэх буудал **Дэд бүтцийн барилга байгууламжийн бүс** **Тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт** **Тусгай хэрэгцээний газар** /Аймаг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй бүх газрын төлөвлөлтийг дээд шатны байгууллагын тогтоосон хил заагаар нь төлөвлөх/ - Улсын хилийн зурвас газар - Хот суурины гаднах улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар - Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай - Чөлөөт бүсийн газар - Цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар - Бусад **Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт** Улсын тусгай хамгаалалтад авах, гаргах бүс нутаг /Зөвхөн тухай шатны/ - Дархан цаазат газар - Байгалийн цогцолборт газар - Байгалийн нөөц газар - Дурсгалт газар Улсын тусгай хамгаалалттай газар нутаг /хадгалан үлдээх/ - /Аймаг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй бүх газрын төлөвлөлтийг дээд шатны байгууллагын тогтоосон хил заагаар нь төлөвлөх/ **Орон нутгийн тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт** Орон нутгийн тусгай хамгаалалтад авах, гаргах бүс нутаг /Зөвхөн тухайн шатны/ - Байгалийн нөөц газар - Дурсгалт газар Отрын бэлчээр /Зөвхөн тухай шатны - Аймаг дундын отрын бэлчээрээс хасах, нэмэх талбай - Сум дундын отрын бэлчээр

		- Сумын отрын бэлчээр - Бусад Хадлангийн талбай /Зөвхөн тухайн шатны/ - Улсын тэжээлийн сангийн хадлангаас хасах, нэмэх талбай - Сум дундын тэжээлийн сангийн хадлангийн талбай - Сумын тэжээлийн сангийн хадлангийн талбай - Бусад Үйлдвэр, уурхай - Бичил уул уурхай зориулалтаар олгох талбай - Үйлдвэр, технологийн парк Аймаг дундын отрын бэлчээр - /Аймаг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй бүх газрын төлөвлөлтийг дээд шатны байгууллагын тогтоосон хил заагаар нь төлөвлөх/ Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай - /Аймаг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй бүх газрын төлөвлөлтийг дээд шатны байгууллагын тогтоосон хил заагаар нь төлөвлөх/ Түүх соёлын дурсгалт газар - Түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс Бусад **Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтоох** - Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бодитойгоор тогтоож ямар хэмжээний газарт, ямар төрлийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг, ямар хугацаанд хэрэгжүүлэх зэрэг асуудлуудыг тодорхойлно. - Хот суурин газар, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй газар, дэд бүтцийн газарт дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газар нутгийн байршил, зааг, хэмжээг тогтооно. - Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ тогтоох, төлөвлөлтийн арга хэмжээнд тусгахдаа "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал"-ыг баримтална. **Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө** Холбогдох хууль журам, дүрмээр тогтоосон хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсүүдийн талаар хийсэн судалгаануудыг үндэслэж /хэрвээ хийгдээгүй бол шинээр хамгаалалтын бүсүүдийг тогтоож зураглах/ түүн дотор дагаж мөрдөх дэглэмийг сахиулах арга хэмжээ болон газар, байгалийн нөөцийг ашиглах зориулалт хэмжээг тус тус тодорхой зааж өгч төлөвлөнө. - Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн төрөл дэглэм хэмжээ - Ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсийн төрөл дэглэм - Шугам сүлжээний газрын хамгаалалтын бүсийн төрөл, хэмжээ - Авто замын хамгаалалтын бүсийн төрөл, дэглэм хэмжээ

		Газрын нэгдмэл сангийн экспликацийг гаргах - Төлөвлөлтийн үр дүнд газрын нэгдмэл санд орох өөрчлөлтийг харуулсан экспликацийг гаргах **Газрын чанарын өөрчлөлт, доройтлыг тогтоох** - Бэлчээр, тариалан болон атаршсан газар, хот, тосгон бусад суурины газар, улсын тусгай хамгаалалттай газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа судалгааны хамгийн сүүлийн үеийн үр дүн, зевлемжийг судлана. - Газрын чанарыг тодорхойлдог арга, стандартыг ашиглан газрын чанарын өөрчлөлт, доройтлыг дараах байдлаар тодорхойлно. - Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны газрын мониторингийн сүлжээний цэггүй нутаг дэвсгэрт газрын доройтлын индекс LDI -ийг дангаар ашиглан тандан судалгааны аргаар газрын доройтлыг тодорхойлно. Үүнд: - Бэлчээрийн ургац, зүйлийн бүрэлдэхүүн, даац багтаамж - Бэлчээрийн экологийн чадавх - Бэлчээрийн төлөв байдал өөрчлөлт талхлагдал - Хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол - Тариалангийн газрын элэгдэл эвдрэл, ашиглалт - Газрын гадаргын элэгдэл эвдрэл, бохирдол - Бэлчээрийн фото мониторингийн судалгааанд үндэслэж "Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загвар"-ыг ашиглан бэлчээрийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох. Бэлчээрийн төлөв байдлыг сэргэх чадавхийн ангилалаар байршлын зураг гаргаж талбайн хэмжээг тодорхойлох - Тохиромжтой байдлын үнэлгээгээр тариаланд тохиромжтой үр дүн гарсан байршлуудаас хөрсний дээж авч төлөв, байдал чанарыг тодорхойлох **Дунд шатны тайлан боловсруулж хүргүүлэх, танилцуулах** Мэргэжлийн байгууллага хээрийн судалгаа, эхний төсөлжүүлэлтийн үе шатыг хамруулсан дунд шатны гүйцэтгэлийн тайланг боловсруулж аймгийн газрын алба, сумын газрын даамалд хүргүүлнэ. Аймгийн газрын алба, сумын газрын даамал дунд шатны тайланд захилагчийн хяналтыг хийж, ажлын хэсгээр хэлэлцүүлэн дүгнэлт, зевлемжийг мэргэжлийн байгууллага болон ГЗБГЗЗЕГ-т хүргүүлнэ. **Багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх, зохион байгуулах** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад иргэдийн оролцоог хангах үүднээс малчин өрх, тариалан эрхлэгчдийн 45%, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 25%, сумын ЗДТГ-ын ажилтнуудын 70%-ийг судалгаанд хамруулахаар тооцон судалгаа хийнэ.

Уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг, зорилтот бүлгийн уулзалтуудыг хийж сумын эдийн засгийн үндсэн чиглэлийг гаргана.
Үүнд:

- Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх боломж, сонирхол үр ашгийн тооцоо
- Малын үүлдэр угсааг сайжруулах арга зам, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж гарц
- Сумын хэмжээнд чадварлаг боловсон хүчнийг хэрхэн бэлтгэх арга зам
- Хүн амын шилжих хөдөлгөөн сумын эдийн засагт хэрхэн нөлөөлөх болон газар ашиглалтын шинэ хэлбэрээр эдийн засгийг тэлэх зэргээр бусад асуудлууд орно.

Иргэдийн санал бодлыг нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд тусгуулахдаа ашиглалтын олон хэлбэр бүхий газрын хэрэгцээг тодорхойлох нь сумын тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой. Иймээс төлөвлөлтөнд иргэдийн оролцоог хангах үүднээс дараах аргуудыг хэрэглэнэ.
Үүнд: Нүүр тулсан уулзалт, уулзалт ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, асуулгын судалгаа, зорилтот бүлгийн саналаар хийгдсэн зураглал, хэмжилт болон сумын онцлогыг харуулах SWOT дүн шинжилгээ болон PESTEL улс төр, нийгэм эдийн засаг, технологи, хууль эрх зүй, байгаль орчны нөлөөллийн хүчин зүйлийг тодорхойлох шинжилгээг хийнэ

3. ЭЦСИЙН ТӨСӨЛЖҮҮЛЭЛТ

/Судалгааны үр дүнг нэгтгэж төлөвлөгөөний эцсийн хувилбарыг боловсруулна./

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр энэхүү аргачлалын дагуу төлөвлөсөн нийт арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн, хариуцах эзэн, шаардагдах төсөв зардал зэрэг мэдээллийг агуулсан үйл ажиллагааны төлөвлөгөөг "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний аргачлал"-ын Хавсралт 2-ын дагуу боловсруулж нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хамт сумын ИТХ-аар хэлэлцүүлж батлуулна.

Цахим системд бүртгэх

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг цахим системд бүртгэх асуудлыг "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам"-аар зохицуулна.

Мэргэжлийн байгууллага нь цахим системд зурагласан ерөнхий төлөвлөгөөний арга хэмжээ, бүсчлэлийн зурган мэдээллийн давхаргын атрибут агуулгын бүрэн бүтэн байдал, геометр, топологи алдаа зэргийг шалгаж мэдээллийн сангийн загвар, стандартад нийцүүлэн зурагласан байна.

Хэрэв иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний эцсийн шатны тайланг хэлэлцүүлэх явцад өөрчлөлт

		хийх, нэмж тусгах санал гарсан тохиолдолд уг өөрчлөлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэмдэглэлийн үндэслэн хийх бөгөөд хурлын тэмдэглэлийн хуулбарыг цахим системд заавал хавсарган засварыг хийнэ. Аймгийн газрын алба Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг цахим системд баталгаажуулна. **4. ДҮГНЭЛТ ГАРГУУЛАХ** **Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулах** Төлөвлөгөөний төслийг Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэхийн өмнө аймгийн газрын алба, сумын газрын даамал нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний эцсийн шатын тайланд захилагчийн хяналтыг хийж, ажлын хэсгээр хэлэлцүүлэн дүгнэлт, зөвлөмж гаргаж, мэргэжлийн байгууллага болон тус байгууллагад албан бичгээр хүргүүлнэ. Мэргэжлийн байгууллага нь төлөвлөгөөний эцсийн шатны тайланг аймгийн газрын алба болон сумын газрын даамлын гаргасан дүгнэлтийн хамт газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албан бичгээр хүргүүлж мэргэжлийн дүгнэлт гаргуулна. Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Нэмэлт судалгаа, мэдээлэл шаардлагатай тохиолдолд уг хугацааг 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Төлөвлөгөөний тайлан тоон зургийн иж бүрдэл дутуу, цахим системд байршуулаагүй тохиолдолд дүгнэлт гаргахгүй буцаана. **5. АЛБАЖУУЛАЛТ** **Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг баталгаажуулах, хүлээлгэн өгөх** Аймгийн газрын алба, сумын газрын даамал газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийн дагуу засвар өөрчлөлтийг бүрэн хийсэн эсэхэд хяналт тавьж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, батлуулах ажлыг зохион байгуулна. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн тогтоол гаргаж, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг баталгаажуулна. Тогтоолын агуулгад сумын Засаг даргад нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэх талаар тусгана.

7.	Техникийн шаардлага	1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам" 2. "Геодезийн байрлалын сүлжээг WGS-84 солбицол, өндрийн сүлжээг Балтийн тэнгисийн өндрийн тогтолцоонд байгуулж, зураглалыг UTM тусгагт зохионо. 3. ГЗБГЗЗЕГын даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн А/304 дүгээрр тушаалаар батлагдсан "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй" 4. ГЗБГЗЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/112 дугаар тушаалаар батлагдсан "Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам" 5. ГЗБГЗЗГ-ын 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажилуулах журам" 6. "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны ажиллуулах журам" 7. ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 дугаар тушаалаар батлагдсан "Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ боловсруулах арга зүй" 8. "Үндэсний стандарт шинээр батлах тухай "Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны А/36 дугаар тушаал 9. Төлөвлөлтийн зургийг Монгол улсын стандарт "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:1000, 1:2000, 1:5000 масштабын зургийн таних тэмдэг": MNS 6316:2012, "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:25000, 1:50000, 1:10000 масштабын зургийн таних тэмдэг" MNS 6317:2012, "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:500000, 1:1000000 масштабын зургийн таних тэмдэг" MNS 6315:2012 болон атрибут мэдээллийн тоон өгөгдлийн стандарт 10.ГХГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2016 оны А/206 дугаартушаалаар батлагдсан "Улс, бүс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зургийн тоон мэдээлэл боловсруулах заавар" 11.ГХГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2015 оны 01 дүгээр сарын 22-ны А/22 дугаар тушаалаар батлагдсан "Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг бүртгэн баталгаажуулах түр заавар 12.Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан "Газар зохион байгуулалт хийх журам", "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам"
8.	Ажлын хяналт шалгалт	1. Аймгийн ГХБХБГ болон сумын Газрын даамал нь "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах" ажлын захиалагчийн техникийн хяналтыг гүйцэтгэнэ. 2. Захилагчийн техникийн хяналтын зардал нь нийт зардлын 5 хувь байна. 3. Аймгийн ГХБХБГ болон Газрын даамал нь мэргэжлийн байгууллагын сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах үе шат бүрд дүгнэлт гаргана. 4. ГЗБГЗЗЕГ-нь сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний эцсийн шатны тайланд мэргэжлийн дүгнэлт гаргана. /Үе шатны

		дүгнэлт болон төлөвлөгөөний иж бүрдэл дутуу, цахим системд байршуулаагүй тохиолдолд дүгнэлт гаргахгүй буцаана./ 5. ГЗБГЗЗЕГ-ын мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө"-ний төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж төлөвлөгөөг батлуулна.
9.	Хүлээлгэн өгөх материал	Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө цахим системд батлагдсны дараа мэргэжлийн байгууллага батлагдсан нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний иж бүрдлийг тоон болон хэвлэмэл байдлаар сумын Засаг даргын тамгын газар, сумын Газрын даамал, аймгийн газрын алба, Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус бүр 1 хувийг холбогдох журам, зааврын дагуу хүлээлгэн өгнө. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний иж бүрдэл дараах баримт бичгүүдээс бүрдэнэ. Үүнд: • Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний тайлан 1 боть; • Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний суурь судалгааны тайлан 1 боть /хээрийн судалгааны ажилд ашигласан судалгааны материалуудыг оруулах/; • Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний зургийн эмхэтгэл 1 боть; • Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө; • Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичиг болон төлөвлөлтийн зургийн тоон мэдээлэл, зургийн эхийг бэлтгэсэн прожект файл; /MXD, shapefile/-DVD • Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний цахим системд байршуулж баталгаажсан төсөл; • Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймгийн газрын алба, сумын газрын даамлын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний үе шат бүрд гаргасан дүгнэлт, зөвлөмж, ГЗБГЗЗЕГ-ын мэргэжлийн дүгнэлт.
10.	Захиалагч байгууллага	1. Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар 2. Төв аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
11.	Гүйцэтгэгч байгууллага	Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага байна.
12.	Санхүүжилт, эх үүсвэр	1. Төлөвлөгөө боловсруулах үе шат бүрт явцын дүгнэлт гаргуулж акт үйлдсэний дараа санхүүжилтийг шийдвэрлүүлнэ. 2. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах төсөв зардлын 5-аас доошгүй хувийг ажлын үе шатны гүйцэтгэлийн явц, чанарыг шалгах шинжээчдийн баг ажиллуулахад зарцуулна. 3. Санхүүжилтийг дараах хуваарийн дагуу хийнэ. Үүнд: 3.1. Эхний санхүүжилт – 30 хувь /Гэрээ байгуулсны дараа/ 3.2. Хоёр дахь санхүүжилт- 30 хувь /Дунд шатны төлөвлөгөөг ажлын хэсгээр хэлэлцүүлж, дүгнэлт зөвлөмж гарсаны дараа/

		3.3. Эцсийн санхүүжилт - 40 хувь /Батлагдсан нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг ГЗБГЗЗЕГ-ын ажил хүлээн авсан акт гарсаны дараа/
13.	Ажлын онцгой нөхцөл	Орон нутгийн ба улсын тусгай хамгаалалттай газар ажиллах бол зөвшөөрөл авах.
14.	Төрийн нууцыг хадгалах, хамгаалах	• Төрийн болон албаны нууцын тухай хууль • Монгол улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам
15.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

ХЯНАСАН:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ИХБАЯР

ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.БАДАМГАРАВ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ГАЗРЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.БАТЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ПҮРЭВЖАРГАЛ

ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ч.НАРАН

БАЯНЦАГААН СУМЫН ГАЗРЫН ДААМАЛ Б.НАМСРАЙЦЭРЭН